



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/276

Булган сум

### Эрх шинэчлэн олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн энгийн зөвшөөрлийн жагсаалтын 3.3, 4.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6 дахь заалт, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 148 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 3 дахь заалт, 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай дүрэм"-ийг хавсралтын 4.2 дахь заалт, 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-ийн хавсралтын 3.1.2, 3.2, 7.2 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын 1 дүгээр хавсралтын 2.2, 3.2, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.23 дахь заалтаас бусад барилга байгууламж, авто замын угсралт, өргөтгөл шинэчлэл, тохижилт, засварын ажлын зөвшөөрлийн хүсэлтийн дагуу баримт бичгийн бүрдлийг бүрдүүлж Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтын дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгож ажиллах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Барилга байгууламж, авто замын угсралт, өргөтгөл шинэчлэл, тохижилт, засварын ажлын үр дүнд мэргэжлийн үнэлэлт өгч ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу баримт бичгийг бүрдүүлж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах эсэхийг шийдвэрлэх улсын комиссын бүрэлдэхүүнийг тус тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу томилох эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/803 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010692

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР